

Монгол Улс
Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл (ХЭДТ)
Олон улсын хөгжлийн ассоциацийн зээлийн дугаар: P159215

Ажлын даалгавар
Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний байр/танхимыг үйлчилгээний шинэлэг зохион байгуулалтын дагуу засварлахад зориулж үйлчилгээний брэндиг стратегийг боловсруулах

Төслийн танилцуулга

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам нь “Хөдөлмөр Эрхлэлтийг Дэмжих Төсөл” (ХЭДТ)-ийг Дэлхийн Банкны санхүүжилттэй хэрэгжүүлж байна. Уг төсөл нь ажил хайгчид болон бичил бизнес эрхлэгчдийн хөдөлмөрийн зах зээлийн боломжуудыг нэмэгдүүлэхэд зорилготой, харилцан уялдаа бүхий гурван үндсэн бүрэлдэхүүнтэй. Нэгдүгээр бүрэлдэхүүн хэсэг нь хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг үйлчлүүлэгч төвтэй болгож хөгжүүлэх, төрийн ба хувийн хэвшлийн хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний байгууллагуудын хамтын ажиллагааг бэхжүүлэх, хоёрдугаар бүрэлдэхүүн хэсэг нь хөдөлмөрийн зах зээлийн зарим идэвхтэй хөтөлбөрийг шинэлэг аргачлалаар төлөвлөн турших, гуравдугаар бүрэлдэхүүн хэсэг нь хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, нотолгоонд суурилсан шийдвэр гаргахад нь бодлого боловсруулагчид, иргэдэд дэмжлэг үзүүлэх, мөн төслийн удирдлага, хяналт, үнэлгээг дэмжих зорилготой.

Бүрэлдэхүүн 1-ийн хүрээнд аймаг, дүүргийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсүүдийн үйлчилгээний байр, танхимын дотоод заслыг хийж гүйцэтгэнэ. Сонгогдсон газар, хэлтсүүдийн үйлчилгээний байр, танхимыг шинэчлэн зассанаар үйлчлүүлэгч төвтэй төрийн үйлчилгээг нэвтрүүлэхэд дөхөм болох юм. Тухайлбал, засварын ажил нь үйлчилгээний зохион байгуулалт, зөвлөх, ажилд зуучлах үйлчилгээний үр дүнг дээшлүүлэх ажлыг дэмжинэ. Засварын ажлын ерөнхий хүрээ, агуулгыг ХНХЯ болон Дэлхийн банк хамтран боловсруулсан болно. (Дэлгэрэнгүйг доорх хайрцгаас харна уу)

Аймаг, дүүргийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсүүдийн дотоод засварын ажлын агуулга, хүрээ

1) *Үйлчлүүлэгч төвтэй төрийн үйлчилгээг бий болгоход анхаарсан байна:*

- a. Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний төвийг 1 давхарт байршуулах (Хэрвээ 2 юм уу 3 давхарт байвал 1 давхарт шилжүүлэх боломжтой эсэхээ баталгаажуулсан байх);
- b. Ажил хайгчид өөрийгөө бүртгүүлэх хэсэгтэй байх (хамгийн багадаа 2 суурин компьютер байршуулах);
- c. Тэргэнцэртэй үйлчлүүлэгчдэд ээлтэй орчин (орц, хаалга, ариун цэврийн өрөөний зохион байгуулалт) бүрдүүлэх;
- d. Мэдээлэл (хэвлэмэл товхимол) авах хэсэгтэй байх (хүлээлгийн танхимд);
- e. Хүлээлгийн танхимд хангалттай тооны сандал байршуулсан байх;
- f. Үйлчлүүлэгчдийн ачаалал ихтэй үед ажил хайгчдын урсгалыг зөв зохицуулахуйцаар үйлчилгээг хүргэх боломжтой байх;
- g. Хүйтний улиралд дулаан байх (хаалга болон цонхыг стандартын дагуу суурилуулах).

2) *Зөвлөх, зуучлах үйлчилгээг үр дүнтэй үзүүлэх боломж бүрдүүлсэн байх:*

- a. Ажил хайгчдыг хүлээж авах, ярилцах боломж бүхий орчин бүрдүүлэх (2-3 зөвлөх тусгаарлагч хана бүхий орчинд ажиллах);
- b. Ганцаарчилсан зөвлөгөөний өрөөтэй байх;
- c. Бүлгийн мэдээлэл, сургалтын танхимтай байх (дор хаяж 15 хүний багтаамжтай)

3) *Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний оновчтой зохион байгуулалтыг дэмжих бусад ажил:*

- a. Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний хэлтэс/ албаны даргын ажлын өрөөг шилэн ханаар тусгаарлах, ингэснээр үйлчилгээний явц байдлыг хянах боломжтой болно;
- b. Төсөл, хөтөлбөр хариуцсан 2-3 мэргэжилтний ажиллах хэсгийг засварлах, гэхдээ тусгаарлагч хана шаардлагагүй;
- c. Боломжтой бол ажилтнуудын цайны өрөө\хэсэгтэй болгох; (түхэйн газар/хэлтсийн удирдлагатай ярилцах)
- d. Агуулахын өрөөтэй байх; (шаардлагатай тохиолдолд) (түхэйн газар/хэлтсийн удирдлагатай ярилцах).

4) *Шинэчлэл/засварын ажлын хамрах хүрээ:*

- a. Зөвхөн дотоод заслын ажил хийгдэнэ (дээрх орчинг бүрдүүлэхийн тулд үйлчилгээний давхрын холбогдох хэсгийн план зургийг өөрчлөх, дотоод засалтай холбоотой ажлууд хийгдэнэ);
- b. Зайлшгүй шаардлагатай тохиолдолд гаднах хэсгийн жижиг засварууд хийх боломжтой (цонх солих, үүдний хэсгийн ханыг будах, Хөгжлийн бэрхшээлтэй иргэн ээлтэй зорчих нөхцөлийг бүрдүүлэх, байрны дулаан хадгалалтыг сайжруулах зорилгоор үүдний хаалгыг солих гэх мэт;)
- c. Дээврийн засварын ажил хийгдэхгүй.
- d. Сантехникийн томоохон засварын ажил хийгдэхгүй.

Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний брэндинг: Засварын ажил эхлэхээс өмнө ХНХЯ хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний брэндинг стратегийг боловсруулах зөвлөхийг шалгаруулж ажиллуулна. Брэндингийн зөвлөх нь хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээнд ашиглах өнгө, брэндийн агуулга, стратегийг боловсруулах ба тэдгээрийг засварын ажилд нэгдмэл байдлаар тусгана. (тусгаарлалт, ханын будагны код...гэх мэт)

Энэхүү ажлын даалгавар нь хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний шинэлэг өнгө төрх, дэвшилтэт арга барилыг олон нийт, үйлчлүүлэгчдэд таниулж хоногшуулахад чиглэсэн брэндингийн концепц ба стратегийг боловсруулах үндэсний зөвлөхийн ажлын хүрээг тодорхойлно. Уг ажил нь хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний мөн чанар, нийгэмд оруулах хувь нэмэр, бусад үйлчилгээнээс ялгарах байдал, түхэйлбал үйлчилгээний байр\танхимын интерьерийн онцлох элементүүдийг тодорхойлж, боловсруулахад чиглэгдэнэ. Брэндингийн стратегийг хэрэгжүүлэхэд төвөггүй, нийт үйлчилгээнд нэвтрүүлэхэд ихээхэн төсөв зардал шаардахааргүй байх шаардлагатай.

Зөвлөхийн боловсруулсан брэндингийн концепц, стратегийг хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний байр\танхимыг засварлах ажилд тусгах юм. Үйлчилгээний байр\танхимыг засварлах ажил 2019, 2020 оны зун хийгдэнэ. Брэндингийн зөвлөхийн ажиллах хугацаа нь засварын ажлыг төлөвлөх,

хянах чиг үүрэгтэй барилгын инженерүүдийн ажиллах хугацаатай уялдана. Барилгын инженерүүд засварын ажлын ерөнхий зураг төсөл, аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний байр\танхимын засварын зураг төслийг нэгж бүрээр боловсруулна. Тиймээс, брэндингийн стратегийг аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний байр тус бүрийн засварын ажилд тусгаж хэрэгжүүлэх юм.

<p>Зөвлөхийн гүйцэтгэх ажил</p>	<p>1) Холбогдох байгууллагуудын мэргэжилтэн, албан тушаалтнуудтай уулзаж ярилцана. Хөдөлмөр эрхлэлтийн салбарын байгууллагууд, тухайлбал ХНХЯ, ХЭДТ-ийн нэгж, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар, Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газар зэрэг холбогдох байгууллагуудын мэргэжилтэн, албан тушаалтнуудтай уулзаж ярилцана. Түүнчлэн, нийслэлийн аль нэг дүүрэг дэх хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний өдөр тутмын үйл ажиллагаатай газар дээр нь очиж танилцан, ажиглалт хийх нь зүйтэй бөгөөд энэ нь брэндингийн санаагаа хөгжүүлэхэд тус дөхөм болно. Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг шинэ түвшинд гаргаж хөгжүүлэх, тухайлбал, үйлчилгээний процесс, үр дүнг сайуруулах, үйлчилгээний байр\танхимыг засварлах ажилтай холбогдсон төлөвлөгөөт үйл ажиллагааны талаар ХЭДТ-ийн ажилтнууд зөвлөхөд дэлгэрэнгүй мэдээлэл өгнө.</p> <p>2) Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний брэндингийн концепцийг боловсруулах. Холбогдох байгууллагуудын төлөөлөл, ажилтнуудтай уулзаж ярилцахын зэрэгцээ хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний талаар судалж, ерөнхий ойлголт, мэдлэгтэй болсны үндсэн дээр Монгол улсын хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний шинэ дүр төрхийг илтгэх брэндингийн концепцийг боловсруулна. Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг үйлчлүүлэгч төвтэй, илүү үр нөлөөтэй, оновчтой зохион байгуулах гэсэн алсын харааг чухалчлан анхаарна. Брэндингийн концепц, стратегийг боловсруулах гэдэгт хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний шинэлэг төрх, байдлыг түүштай илэрхийлэх чухал элементүүдийг боловсруулах гэж ойлгоно. Үүнд, үйлчилгээнд хэрэглэх таних тэмдэг \лого\, үйлчилгээний байр\танхимын интерьерт хэрэглэх онцлог өнгө, дизайны элементүүдийг тодорхойлох ажлуудаас эхэлнэ. Зөвлөх нь боловруулсан концепцоо ХЭДТ-ийн ажилтнуудад танилцуулах бөгөөд шаардлагатай бол ХНХЯ, ХХҮЕГ-т танилцуулах ажлыг ХЭДТ зохицуулж өгнө.</p> <p>3) Брэндингийн стратегийг боловсруулах. Зөвлөх нь улмаар хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний брэндинг стратегийг боловсруулна. Мөн уг стратегийг хэрхэн хэрэгжүүлэх, тухайлбал үйлчилгээний байр\ танхимын засварт хэрхэн хэрэгжүүлэх талаар зөвлөмж боловсруулна.</p>
<p>Зөвлөхөд тавигдах шаардлага</p>	<p>Дараах шаардлагыг хангасан иргэнийг зөвлөхөөр сонгон шалгаруулна:</p> <ol style="list-style-type: none"> 1. Маркетингийн зөвлөх үйл ажиллагааны чиглэлээр 3-аас доошгүй жил ажилласан туршлагатай байх; 2. Бараа, үйлчилгээний брэндингийн концепц, стратегийг боловсруулж байсан туршлагатай байх; 3. Интерьерийн дизайны шийдэл боловсруулах туршлагатай бол давуу тал болно; 4. Шахуу цаг хугацаанд ажиллах чадвартай байх. <p>Зөвлөх нь ажлын туршлага, хийсэн бүтээлээ нотлох бичиг баримт, танилцуулгыг бүрдүүлсэн байна.</p>

Явцын тайлан, үр дүнг хянах	Зөвлөх нь дээр дурдсан ажлыг ХНХЯ-ны ТХН-ийн хяналт дор гүйцэтгэнэ. Зөвлөхийн ажлын гүйцэтгэлийг дараах шалгуур үзүүлэлтээр үнэлнэ. Үүнд: <ul style="list-style-type: none"> - Ажлын даалгаварт тусгасан ажлуудыг бүрэн гүйцэтгэсэн байдал; - Төлөвлөсөн ажлуудаа хугацаанд нь хэрэгжүүлсэн байдал; - Гүйцэтгэсэн ажлын чанар.
Төсөл хэрэгжүүлэх нэгжээс үзүүлэх дэмжлэг	Зөвлөх нь ХЭДТ-ийн нэгжийн оффис, техник хэрэгслийг ашиглаж болно.
Хугацаа	Зөвлөх нь 2019 оны 5-дугаар сарын 1-нээс 21 –ний хооронд ажлын 15 хоногийн хугацаатай ажиллана.
Нийлүүлэх бүтээгдэхүүн	Зөвлөх нь дараахь бүтээгдэхүүнийг нийлүүлнэ. Үүнд: <ol style="list-style-type: none"> 1. Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний брэндингийн концепц 2. Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний брэндингийн стратегийг тайлбарласан богино хэмжээний ном 3. Хийж гүйцэтгэсэн ажил, уулзаж ярилцсан хүмүүсийн нэр, брэндингийн стратегийг хэрэгжүүлэхэд анхаарах асуудал зэргийг тусгасан тайлан
Ажлын хөлсний төлбөрийн хуваарь	Зөвлөхийн нийлүүлсэн бүтээгдэхүүнийг хүлээн авч, бүх ажлыг үр дүнтэй хэрэгжүүлсэн гэж үзсэний үндсэн дээр ажлын хөлсийг нэгмөсөн шилжүүлнэ.